



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/265

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "в", 30 дугаар зүйлийн 30.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2018 оны 271 дүгээр тогтоол, Монгол Улсын шадар сайдын 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах түр журам, аймгийн Онцгой комиссын 2020 оны 25 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Хот хоорондын хяналтын постод хэрэглэж байгаа ариутгал халдваргүйтгэлийн бодис, ажиллаж байгаа албан хаагчдын хамгаалах хэрэгсэл, зайнаас халуун хэмжигч зэрэг бусад хэрэглэгдэхүүнийг худалдан авах зардалд 1.446.600 (Нэг сая дөрвөн зуун дөчин зургаан мянга зургаан зуу) төгрөг, хяналтын постод болон аймгийн шуурхай штабт үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг хангах зардалд 1.671.900 (Нэг сая зургаан зуун далан нэгэн мянга есөн зуу) төгрөг, сорьц тээвэрлэлтийн зардалд 900.000 (Есөн зуун мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх 4.018.500 (Дөрвөн сая арван найман мянга таван зуу) төгрөгийг аймгийн аймгийн Онцгой байдлыг газрын нэмэлт төсвийн дансанд төвлөрсөн хандивын хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга (Ё.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Баттогтох)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

Захирамж-2020

01120201